

Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн ТОЙМ

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.05.16

Олон улсын  
хөрөнгийн зах зээл

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ


Онцлох индексүүдийн өөрчлөлт

Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

АНУ-ын индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dow Jones	\$32,196.66	\$32,899.37	-2.14%	\$32,196.66	0.00%	\$34,327.79	-6.21%
S&P 500	\$4,023.89	\$4,123.34	-2.41%	\$4,063.08	-0.96%	\$4,063.08	-0.96%
Nasdaq	\$11,805.00	\$12,144.00	-2.79%	\$13,546.85	-12.86%	\$13,429.98	-12.10%

Европын индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dax	€ 14,027.93	€ 13,694.17	2.44%	€ 14,119.38	-0.65%	€ 15,199.68	-7.71%
FTSE 100	£7,418.15	£7,386.75	0.43%	£7,386.75	0.43%	£6,963.30	6.53%

Азийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
CSI 300	¥3,988.60	¥3,984.56	0.10%	¥3,984.56	0.10%	¥3,984.56	0.10%
Hang Seng	HKD 19,898.77	HKD 20,277.85	-1.87%	HKD 21,424.78	-7.12%	HKD 27,718.67	-28.21%
Nikkei 225	JPY 26,427.65	JPY 26,661.26	-0.88%	JPY 27,137.06	-2.61%	JPY 27,448.01	-3.72%



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### ЭНЭ 7 ХОНОГТ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АЖИГЛАХ ТАВАН ЗҮЙЛС

Энэ 7 хоногт хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргахын тулд дараах таван зүйлсийг анхааралтай ажиглахыг хөрөнгө оруулагчид сануулж байна.

#### 1. АНУ-ын эдийн засгийн мэдээлэл зарлагдана

ХНС-аас өсгөсөн бодлогын хүүгийн шийдвэр нь эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа нь энэ 7 хоногт зарлагдах 4 сарын эдийн засгийн тоон мэдээллээс тодорхой болно.

Тодруулбал, мягмар гарагт жижиглэнгийн худалдааны борлуулалт, бүс нутгийн үйлдвэрлэлийн тоон мэдээ, орон сууцны борлуулалтын үзүүлэлтүүд зарлагдах юм.

#### 2. АНУ-ын жижиглэнгийн худалдааны ашиг хэр байх вэ?

Хөрөнгө оруулагчид эдийн засгийн мэдээллээс гадна компаниудын жижиглэнгийн худалдаанаас олж буй цэвэр ашгийн үзүүлэлтийг хүлээж байна.

Мягтар гарагт Walmart, Home Depot компани нэгдүгээр улирлын тайлангаа танилцуулах бол пүрэв гарагт Target, Lowe's компаниуд тайлангаа тавина.

#### 3. Хөрөнгийн зах зээлийн уналт дуусаж буй эсэх

Баасан гарагт АНУ-ын голлох индексүүд өссөн ч 7 хоногийн өмнөх ханштай харьцуулахад унасан байна.

S&P 500 болон Nasdaq индексүүд зургаан 7 хоног дараалан унасан бол Dow Jones долоон 7 хоног дараалан унажээ. Хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлийн уналтын дуусах цэгийг олохын тулд тодорхой шинж тэмдгийг хайж байна. Харин судлаачид уналт дуусах цэгийг олох нь бэрхшээлтэй тул шилжих хөдөлгөөнийг анхааралтай ажиглах нь зүйтэй гэж мэдэгдэж байна.

#### 4. Криптовалютын уналт үргэлжлэх үү?

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханшийг дагадаг Terra криптовалютын ханш унасан. Terra нь тогтвортой криптовалют байх ёстой ч ханш нь унасан нь зах зээл дээр томоохон шуугиан дэгдээсэн юм.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Тиймээс энэ 7 хоногт криптовалютын зах зээл хэр их савлах, хөрөнгө оруулагчид тус үйл явдлын дараа үргэлжлүүлэн арилжаа хийх эсэхийг ажиглах нь зүйтэй юм.

### 5. Их Британийн инфляцийн түвшин зарлагдана

Их Британи улс лхагва гарагт 4 сарын инфляцийн тоон мэдээллээ зарлана. Шинжээчид хэрэглээний үнийн өсөлтийг жилийн өмнөхөөс 9.1 хувиар өсөх бөгөөд энэ нь 1980 оноос хойш тохиож буй хамгийн өндөр өсөлт байх болно гэж таамаглаж байгаа юм.

Английн төв банк энэ жилийн сүүлчээр инфляцийг 10 хувь хүрнэ хэмээн таамагласан.

Харин мягмар гарагт хөдөлмөрийн зах зээлийн талаарх тоон үзүүлэлт нь гарах бөгөөд иргэдэд учирч буй үнийн дарамт, цалин хөлс зэрэг нь тодорхой болно.

### Өнөөдөр БНХАУ-ын 4 сарын эдийн засгийн үзүүлэлтүүдийг зарлана

Өнөөдөр БНХАУ 4 сарын аж үйлдвэрлэл, жижиглэнгийн борлуулалт, тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүний хөрөнгө оруулалт, ажилгүйдлийн түвшний талаарх тоон мэдээллээ тайлагнана.

Хөрөнгө оруулагчид тус улсын ковидын эсрэг авч буй арга хэмжээ нь эдийн засагт хэрхэн нөлөөлж буйг энэхүү тоон мэдээллээс харах боломжтой.

Австралийн төв банкны хувьд БНХАУ-ын 4 сарын эдийн засгийн үзүүлэлтийг тааруу гарах магадлалтай гэж үзэж байна.

Шинжээчдийн таамаглалаар тус улсын жилийн жижиглэнгийн борлуулалт 6.1 хувийн уналт, аж үйлдвэрлэлтийн тоон хэмжээ 0.4 хувийн өсөлт үзүүлнэ.

Тус улс ковидын нөхцөл байдлаас болж ДНБ-ий жилийн өсөлтийн таамаглалаа 4.3 хувь болгож бууруулсан.

Хөрөнгө оруулагчид энэхүү эдийн засгийн мэдээллийг хүлээж байгаа тул тус улсын хувьцаанд шууд хөрөнгө оруулалт хийхээс эмээж байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS Most Anticipated Earnings Releases for the week beginning May 09, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
Palantir	Upstart	PELOTON	SoFi	YETI	Walt Disney	Six Flags	affirm	Biofrontera	
BIOTECH	AMC	NORWEGIAN CRUISE LINE	RQBLX	fiverr.	SANDSTORM	veru	AURORA	LifeMD	
Tyson	SUNCOR	Sysco	OXY	EVgo	RIVIAN	Hillmax	indie	NYC NEW YORK CITY REIT	
DUKE ENERGY	PLUG POWER	Builders FirstSource	theTradeDesk	Wendy's	Dutch Bros	tapestry	COMPASS	IMV	
COTY	novavax	理想	coinbase	Wendy's	BEYOND MEAT	Immersion	FIGS	McEwen Minerals	
GLOBAL VEST LEASE	Clover	WORKHORSE	unity	Paysafe	STERILIS	US FOODS	Rockley	HONEST	
ATERIAN	BAUSCH+HEALTH	ARRAY TECHNOLOGIES	uSunn	ICL	KINROSS	endava	Joby	HUMACYTE	
LORSTOWN	Talend Chief	Aurinia	Matterport	EPFG	SONOS	Crescent Point	Navitas	PLX PHARMA INC.	
HILTON GRAND VACATIONS	blink	CRONOS GROUP	ROCKET Companies, Inc.	ATOTECH	bumble	bakkt		SOPI	
Adaptive Immune	Lemonade	Village Farms		MASTERCRAFT BOAT HOLDINGS INC.	coupang	CYBERARK	MOTOROLA SOLUTIONS	Hippo	
http://eps.sh/cal						© 2022 Earnings Whispers			

## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS Most Anticipated Earnings Releases for the week beginning May 16, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
WIX	SUNDIAL	Walmart	doximity	ZIM	CISCO	lightspeed	APPLIED MATERIALS	JOHN DEERE	
Tower Semiconductor	T2	THE HUMAN EDGE	KEYSIGHT TECHNOLOGIES	TARGET	SQM	KOHL'S	paloalto	Foot Locker	
monday.com	danana	sea	d-local	LOWE'S	SYNOPISS	B's	ROSS DRESS FOR LESS	Buckle	
WEBER	HIGHPEAK	JD.COM	Agilysys	TJX	Bath & Body Works	GOLDEN OCEAN	V CORPORATION	Booz   Allen   Hamilton	
WARBY PARKER	stratasys	AERCAP	QuickLogic	ANALOG DEVICES	GOS 万国数据	CANADA GOOSE	DECKERS BRANDS	RLX TECHNOLOGY	
搜狐 SOHU.COM	HELBIZ	PALATIN	nextgen healthcare	Arco Dorados	Copart	ADS	Flowers FOODS	Anterix	
HOOKIPA	Global e	quipt	The Container Store	COGATE-PALMOLIVE	ibex.	EM Eagle Materials	APOLLO INTERNATIONAL CORPORATION		
Bitfarms	TENCENT MUSIC ENTERTAINMENT	JANUS	Lulus	dynatrace	HAWKINS	NANOX	Globant		
CLEAR	nu	g	QUALTRIC	Triumph Group	CIST	MONRO	BBVA		
MindMed	SUPER LEAGUE	allot		DOUYU.COM		CAE			
http://eps.sh/cal						© 2022 Earnings Whispers			

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.